

Зураг төслийн баримт бичгийн

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР: УЛААНБААТАР ХОТ, ХАН-УУЛ ДҮҮРЭГ, 4-Р ХОРОО, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, 20-Р ХОРОО, НААДАМЧДЫН АВТО ЗАМААС ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ ХҮРТЭЛХ АВТО ЗАМЫН 1-Р ХЭСГИЙН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ, ЗУРГИЙН ДУГААР: ГУК-01/22

2023 оны 01-р сарын 26-ны өдөр

Д/Д	Утга	Тайлбар
1	Объектын нэр:	УБ хот, ХУД, 4-р хороо, БГД, 20-р хороо, Наадамчдын авто замаас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх авто замын 1-р хэсгийн ажлын зураг төсөл
2	Объектын байршил, хүчин чадал:	УБ хот, ХУД, 4-р хороо, БГД, 20-р хороодын нутаг дэвсгэрт хамрагдана.
3	Зураг төслийн байгууллага:	"ГЕО УРБАН КОНСАЛТИНГ" ХХК
3. Дүгнэлтийн товч утга: /Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 168 дугаар тушаалын 9 дүгээр зүйлээс/		
4	9.9.1 авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	Өндөр далантай хэсэгт явган хүний замын гадна захаар хайс төлөвлөх;
5	9.9.2. инженерийн шийдэл, бүтэц нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	Туул голын хөндийгөөр өнгөрч буй хэсэгт замын дээд талд далангийн хормойгоор 5м-ээс ойргүй зайтай шуудуу төсөллөж, гадаргуун болон хөрсний усны замд үзүүлэх нөлөөллийг бууруулах;
6	9.9.3. авто зам, замын байгууламжийн чиглэл, байршил, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт;	Шинээр төсөллөж буй уулзваруудын нэвтрүүлэх чадварын хэтийн төлвийн тооцоо, урсгал, чиглэлүүдийн ачааллын тооцоонд үндэслэн уулзваруудыг төлөвлөх;
7	9.9.4. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	Туул голын хөндийгөөр өнгөрч буй хэсэгт замын хучилтын бүтээцэд далангийн доод үеийн материалд тавигдах шаардлагыг тодорхой тусгах;
/Монгол улсын Засгийн газрын 108 дугаар тогтоолын 6 дугаар зүйлээс/		
8	6.12.3. барилга байгууламжийн гаднах ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	Голын их усны түвшний тооцоонд үндэслэн далангийн хажуу налуун бэхэлгээг төлөвлөх;
9	6.12.5. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	Наадамчдын авто замын уулзвар дээр явган хүний гарцыг зорчих хэсгээс өөр түвшинд төлөвлөх;
10	6.12.6. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл;	
11	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	Уулзваруудын зай хэмжээг үзүүлэх; Уулзваруудын эргэлтийн радиусыг төсөллөхдөө угсраа автобус эргэл нөхцөлийг хангахад анхаарах /тооцоот тээврийн хэрэгслээр автобусыг сонгох/;
12	6.12.8 Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	Зорчих хэсгийн гол хэсгээр байрлах ногоон зурвас дээр шөнийн цагт эсрэг урсгалын гэрэл цохихоос хамгаалсан зориулалтын хаалт байрлуулах;
Дүгнэлт бичсэн: Засвар сайжруулалтуудыг хийж дахин хянуулах Эксперт № _____ /овог, нэр / 2023 оны 01-р сарын 26-ны өдөр		



## Зураг төслийн баримт бичгийн

### МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2


**ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР: УЛААНБААТАР ХОТ, ХАН-УУЛ ДҮҮРЭГ, 4-Р ХОРОО, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, 20-Р ХОРОО, НААДАМЧДЫН АВТО ЗАМААС ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ ХҮРТЭЛХ АВТО ЗАМЫН 1-Р ХЭСГИЙН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ, ЗУРГИЙН ДУГААР: ГУК-01/22**

2023 оны 02-р сарын 28-ны өдөр


Д/Д	Утга	Тайлбар
1	Объектын нэр:	УБ хот, ХУД, 4-р хороо, БГД, 20-р хороо, Наадамчдын авто замаас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх авто замын 1-р хэсгийн ажлын зураг төсөл
2	Объектын байршил, хүчин чадал:	УБ хот, ХУД, 4-р хороо, БГД, 20-р хорооны нутаг дэвсгэрт хамрагдана.
3	Зураг төслийн байгууллага:	"ГЕО УРБАН КОНСАЛТИНГ" ХХК

Д/Д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга
1	Өндөр далантай хэсэгт явган хүний замын гадна захаар хайс төлөвлөх;	Авто замын өндөр далантай хэсэгт явган хүний замын гадна захаар хайс төлөвлөв.
2	Туул голын хөндийгөөр өнгөрч буй хэсэгт замын дээд талд далангийн хормойгоор 5м-ээс ойргүй зайтай шуудуу төсөллөж, гадаргуун болон хөрсний усны замд үзүүлэх нөлөөллийг бууруулах;	Авто замын дээд талд шуудуу төлөвлөсөн.
3	Шинээр төсөллөж буй уулзваруудын нэвтрүүлэх чадварын хэтийн төлвийн тооцоо, урсгал, чиглэлүүдийн ачааллын тооцоонд үндэслэн уулзваруудыг төлөвлөх;	Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тухайн авто замын уулзвар 2 түвшинд огтлолцохоор төлөвлөсөн боловч Энхтайваны өргөн чөлөөнөөс Наадамчдын авто зам дээгүүр Зуунмодны авто зам хүртэлх авто замын 1-р хэсгийн авто замын түр уулзвараар төлөвлөлтийн орон зайд уялдуулан төлөвлөв. Наадамчдын авто замын дээгүүр төлөвлөж буй гүүрэн байгууламж нь төслийн хоёрдугаар үе шатанд төлөвлөж байгаа болно.
4	Туул голын хөндийгөөр өнгөрч буй хэсэгт замын хучилтын бүтээцэд далангийн доод үеийн материалд тавигдах шаардлагыг тодорхой тусгах;	Техникийн шаардлагат далангийн доод үеийн материалын тавигдах шаардлагыг тодорхой тусгав.
5	Голын их усны түвшний тооцоонд үндэслэн далангийн хажуу налуун бэхлэлтээг төлөвлөх;	Дагуу огтлол дээр тусгав.
6	Наадамчдын авто замын уулзвар дээр явган хүний гарцыг зорчих хэсгээс өөр түвшинд төлөвлөх;	Тухайн авто зам нь Наадамчдын авто замтай өөр түвшнээр Зуунмодны авто зам хүртэл үргэлжлэх авто замын 1-р үе шатны ажил бөгөөд тухайн хэсэгт гарч буй уулзвар нь түр уулзвараар төлөвлөгдөж байгаа тул явган хүний гарцыг өөр түвшинд төлөвлөх шаардлагагүй болно.
7	Уулзваруудын зай хэмжээг үзүүлэх; Уулзваруудын эргэлтийн радиусыг төсөллөхдөө угсраа автобус эргэл нөхцөлийг хангахад анхаарах /тооцоот тээврийн хэрэгслээр угсраа автобусыг сонгох/;	Уулзваруудын зай хэмжээ болон координатыг үзүүлэв. Уулзваруудын эргэлтийн радиусыг тооцож AutoCad civil (vehicle Tracking) программаар модель үүсгэж шалгав.
8	Зорчих хэсгийн гол хэсгээр байрлах ногоон зурвас дээр шөнийн цагт эсрэг урсгалын гэрэл цохиоос хамгаалсан зориулалтын хаалт байрлуулах;	Зорчих хэсгийн голын ногоон зурвасаар эсрэг урсгалын машины гэрэл гялбалтаас хамгаалж 0.7-1.0м -ийн өндөртэй бут тарихаар төлөвлөв.

Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № ..... он .... сар ..... өдөр


  
 ..... /овог, нэр/

Биелэлтийн тайлбар бичсэн ..... /овог, нэр/


  
 ..... /овог, нэр/

2023 он 3 сар 01 өдөр